

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ШИВЭЭГОВЬ СУМЫН
ӨРГӨДӨЛ ГОМДОЛ, САНАЛ ШИЙДВЭРЛЭЛТИЙН
2022 ОНЫ 1-Р УЛИРЛЫН МЭДЭЭ

2022.03.25.

2022 оны 1-р улирлын байдлаар Засаг даргад 8, иргэний бүртгэлийн асуудлаар 50, нийт 58 өргөдөл хүлээн авсан. Нийт иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, саналын 57 буюу 98,3 хувийг Засаг дарга болон ЗДТГ-ын бүрэн эрх, эрхлэх асуудлын хүрээнд шийдвэрлэж, 1 буюу 1,7 хувийг шийдвэрлэх шатандаа, хугацаа болоогүй өргөдөл эзэлж байна.

Засаг дарга болон ЗДТГ-т нийт 58 өргөдөл ирсний 50 өргөдөл буюу 86,2 хувь нь иргэний бүртгэлтэй холбоотой асуудлаар, 8 өргөдөл буюу 13,8 хувь нь бусад өргөдөл эзэлж байна.

Засаг даргын Тамгын газарт иргэдээс ирсэн өргөдөл, гомдол, санал шийдвэрлэлтийн талаар авсан арга хэмжээ:

Нэг: Иргэний бүртгэлийн асуудлаар нийт 50 иргэний өргөдөл ирснийг хугацаанд нь шийдвэрлэсэн. Үүнд:

1. Шинэ төрсөн хүүхэд - 5
2. Гэрлэлт – 1
3. Нас баралт - 4
4. Овог нэр өөрчлөлт-1
5. Иргэний үнэмлэхтэй холбоотой - 25
6. Шилжилт хөдөлгөөнтэй холбоотой - 14

Хоёр: Бусад 8 өргөдөл ирсэн. Үүнд: Үйлчилгээний зориулалтын газрыг сунгах тухай 1 өргөдөл, Өвөлжөөний газрыг өөрийн эзэмшилд шилжүүлж өгөх тухай 1 өргөдөл, Давхардсан газрын асуудлыг шийдвэрлэж өгөх тухай 1 өргөдлийг сумын 2022 оны газар зохион байгуулалтын тухай жилийн төлөвлөгөөнд нэмэлтээр тусгаж, ИТХ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөөд байна. Мод үржүүлгийн талбай байгуулах газар хүссэн 1 өргөдөлд МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилсан Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд томилогдсон ажлын хэсгийн хурлаар хэлэлцэж тус иргэнд 2 га газрыг мод үржүүлгийн зориулалтаар ашиглуулахаар шийдвэрлэсэн. Нийтийн эзэмшлийн орон сууцны байрны дээврээс ус гоожсон тухай 1 өргөдөл ирсний дагуу тухайн газрын нөхцөл байдалтай нь багийн Засаг дарга танилцаж, чиглэл өгсний дагуу “Тохилог сууц” СӨХ болон оршин суугаа иргэд хамтран ус гоожсон газрыг тогтоож, засварлан, арга хэмжээ авч ажилласан

байна. Тамхи худалдан борлуулах тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах тухай 1 өргөдлийг сумын Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/31 дүгээр захирамжаар тусгай зөвшөөрлийн хугацааг 2 жилээр сунгасан. Хашаан дотор тарьсан моднуудыг усалж өгөх тухай өргөдөлд иргэний хувийн өмчлөлийн газрын хашаан дотроо тарьсан модыг усалж өгөх боломжгүй тухай хариуг өгсөн.

Эзэмшлийн тариалалтын талбайд гүний цэвэр усны ахуйн зориулалтын худаг гаргаж өгөхийг хүссэн 1 өргөдлийг шийдвэрлэх шатандаа байна.

Хүснэгт №01

2022 оны 1-р улиралд иргэдээс сумын
Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт
хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт
шийдвэрлэлтийн байдал

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн тоо	Шийдвэрлэлт				Шийдвэрлэлт /хувь/
			Шийдвэрлэж хариу өгсөн	Бусад байгууллагад шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэрлэсэн	Хугацаа болоогүй	
1	Засаг даргын Тамгын газар	58	57		-	1	98,3
Дүн		58	57		-	1	98,3

Хүснэгт №02

2022 оны 1-р улиралд иргэдээс сумын
Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт
хандаж ирүүлсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт
/хэлбэрээр/

№	Байгууллагын нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол, санал, хүсэлт	Үүнээс:					
			Бичгээр	11-11 төвөөр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан /амаар/	Бусад /иргэдтэй ажиллах-Нээлттэй өдөрлөгөөр/
1	Засаг даргын Тамгын газар	58	58	-	-	-	-	-
Дүн		58	58	-	-	-	-	-

Өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн агуулга /хувиар/
/хэлбэрээр/

№	Байгууллагын нэр	Зонхилж байгаа асуудал /тоо, нийт өргөдөл, гомдолд эзлэх хувь/
1	Засаг даргын Тамгын газар	Нийт 58 өргөдлөөс: - Иргэний бүртгэлтэй холбоотой 50 /86,2%/ - Бусад өргөдөл 8 /13,8%/

МЭДЭЭ ГАРГАСАН:

АРХИВ, БИЧИГ ХЭРГИЙН ЭРХЛЭГЧ

Б.УУГАНБАЯР

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

П.ГАНЧИМЭГ